

Монгол Улсын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нь

Довчинсүрэнгийн Ганзориг

Доктор (Ph.D), эрдэм шинжилгээний ажилтан, ganzorigdovchinsuren@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн

Цэрэндагвын Гандорж *

Доктор (Ph.D), ахлах шинжээч, gandorj@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Тогоогийн Галбадрах

Хангалт, дэмжлэгийн газрын дарга, togoo2@un.org
Абей муж дахь шилжилтийн үеийн НҮБ-ын Аюулгүй байдлын хүчний ажиллагаа (UNISFA)

Хураангуй

Үндэсний аюулгүй байдлын архитектурын гол бүрэлдэхүүнд Үндэсний аюулгүй байдлыг хангах болон Үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэдийгээр эдгээр хоёр тогтолцоо хоорондоо нягт холбоотой боловч удирдлага, зохион байгуулалтын зарчмаараа тодорхой ялгаатай. Тухайлбал: Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь төрийн байгууллагуудын чадавх, төвлөрсөн шийдвэр гаргалтад тулгуурласан дээрээс доош чиглэсэн босоо удирдлагын бүтэцтэй байдаг. Харин Үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо нь төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, орон нутгийн хамтын ажиллагааг нэгтгэсэн доороос дээш чиглэсэн санаачилга, оролцоог түшиглэсэн бүтэцтэй.

Аливаа хосолмол заналхийлэлд үр дүнтэй хариу арга хэмжээ авахын тулд улс орнууд санхүү, техник, хүний нөөцийн өндөр чадавхтай байх шаардлагатай боловч ихэнх улс оронд эдгээр нөөц хязгаарлагдмал хэвээр байна. Иймээс хосолмол заналхийллийн эрсдэлийг бууруулах, түүнтэй тэмцэх бодлого нь системийн сэтгэлгээ, олон нийтийн өргөн оролцоо, институцийн уялдаа, мэдээллийн дархлаа, инновацад тулгуурлах шаардлагатай. Энэ нөхцөлд Үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлал болон түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо улам бүр чухал ач холбогдолтой болж байна.

Монгол Улсын хувьд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхийн тулд улсын хэмжээний нэгдсэн мэдээллийн санд тулгуурлан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх; салбар дундын уялдааг сайжруулах; үндэсний үнэт зүйлс, уламжлалыг хамгаалан хөгжүүлэх; нийгмийн бүлгүүдийн хоорондын ялгааг бууруулах; төр-хувийн хэвшил-иргэдийн байнгын хамтын ажиллагааг төлөвшүүлэх замаар нийгмийн болон эдийн засгийн дархлааг бий болгох; дэлхийн болон бүс нутгийн тогтворгүй байдлын нөлөөллийг үнэлж, бууруулахад

* Холбоо барих зохиогч

оролцох; нийгмийн амьдралын үйл ажиллагааг гамигийн эрсдэлийн менежменттэй уялдуулах шаардлагатай.

Түлхүүр үгс: *Үндэсний аюулгүй байдал, төр, засаглал, институци, нийгэм, иргэн, үзэл баримтлал, бодлого, стратеги*

Оршил

Монгол Улсад үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын судалгаа эхний шатандаа байгаа бөгөөд онол арга зүйн нэгдсэн суурь, нэр томьёоны тогтолцоо, судалгааны хүрээ, үнэлгээний аргачлал зэрэг нь бүрэн боловсруулагдаагүй байна. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь Үндэсний аюулгүй байдал, төрийн удирдлага буюу засаглал, төрийн институцийн чадавх, нийгмийн бүлэглэл хоорондын харилцаа, нийгмийн тогтвортой байдал, эдийн засгийн тогтолцоо, дэд бүтэц, цахим орчин, хүрээлэн буй орчин зэрэг салбар дунд оршдог. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг тодорхойлох, хэмжих, үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлалыг бодлогын түвшинд хэрэгжүүлэхэд ойлголтын нэгдмэл байр суурийг мэргэжлийн судлаач, бодлого боловсруулагч нарт бий болгох нь чухлаар тавигдах боллоо.

Монгол төрийн стратегийн болон хөтөлбөрийн баримт бичгүүдэд үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо бүрдүүлэх зорилтууд тусгагдсан боловч эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үзэл баримтлалын үндэслэл, гол чиглэлүүдийн тодорхойлолт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, институцийн зохион байгуулалт, түүний зохицуулалтын хүрээ зэрэг асуудлын шинжлэх ухааны үндэслэлийг хангалттай боловсруулаагүй байгаа юм. Энэ нь Монгол Улсад үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын бодлогыг системтэйгээр төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх боломжийг хязгаарлаж байна.

Улс орнуудын үндэсний аюулгүй байдалд өнөөгийн геополитикийн өөрчлөлт, уламжлалт аюул заналхийлэл, цахим мэдээллийн сүлжээ, дижитал хамаарал, хуурамч мэдээ, мэдээлэл, кибер халдлага, мэдээллийн аюулгүй байдлын шинэ шаардлагууд, уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний аюулгүй байдал зэрэг хүчин зүйлийн нөлөө улам бүр нэмэгдэж байна. Энэ нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг хангахад үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх өндөр ач холбогдолтой юм. Монгол Улсад үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын ойлголт, түүнийг ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, бодлогын түвшний шийдэл боловсруулах шаардлага байсаар байна.

Иймээс энэхүү өгүүллээр үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын онол арга зүйн үндсийг тодорхойлох, олон улсын загваруудыг харьцуулан шинжлэх, Монгол Улсад тохирох институцийн болон бодлогын загварын төсөөллийг тодорхойлох, улмаар үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хангах тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж боловсруулахад оршино. Түүнчлэн үндэсний аюулгүй байдал болон сөрөн тэсвэрлэх чадавхын

харилцан шүтэлцэл, түүний хэрэгжилтийг хангах төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцын зарчмыг тогтооход оршиж байна.

Нэг. Үндэсний аюулгүй байдлын ойлголт, хувьсал

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын талаар дурдахаас өмнө Үндэсний аюулгүй байдлын ойлголт, хувьслын талаар товч авч үзье.

Үндэсний аюулгүй байдлын ойлголт нь XX зууны туршид үе шаттайгаар өргөжин тэлж, улс төр цэрэг төвтэй уламжлалт ойлголтоос нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, мэдээллийн орчин, хүний аюулгүй байдлыг хамарсан өргөн хүрээний, олон түвшний, системийн шинжтэй үзэл баримтлал болон хөгжсөн. Энэхүү хувьсал нь олон улсын харилцааны орчин, технологийн хөгжил, даяаршил, улс биш тоглогчдын оролцоо, нөлөө, шинэ төрлийн аюул заналын өсөлттэй шууд холбоотой.

“Үндэсний аюулгүй байдал” гэсэн тодорхойлолтыг цаг тооллын хувьд хэрхэн өөр өөрөөр авч үзэж байсныг дурдвал: “Улс дайн гарахаас зайлсхийхийн тулд өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо золиослох шаардлагагүй байх, мөн хэрэв сорилт тулгарвал тэдгээр ашиг сонирхлоо дайны замаар хамгаалах чадвартай байхыг” (Lippmann, 1943); “Үндэсний аюулгүй байдлын онцгой утга нь гадаадын шахалт, зааварчилгаанаас ангид байх явдал гэж” (H.D.Lasswell, 1950); “Объектив утгаараа олж авсан үнэт зүйлсэд заналхийлэл байхгүй байх, субъектив утгаараа эдгээр үнэт зүйлс халдлагад өртөх вий гэсэн айдас байхгүй байхыг” (Wolfers, 1962); “Улсын нутаг дэвсгэр, бие даасан байдлыг хамгаалах, дэлхийн бусад улс оронтой эдийн засгийн харилцаагаа зохистой нөхцөлөөр хадгалах, улс орны мөн чанар, институт, засаглалын тогтолцоог гадаадын нөлөөллөөс хамгаалах, хил хязгаараа хянах чадвар гэж” (Brown, 1983); “Тухайн нийгмийн олон нийтийн ойлголтоор өөрийн тусгаар тогтнол, хөгжил цэцэглэл, сайн сайхан байдлыг хангахад зайлшгүй гэж үздэг дотоод ба гадаад нөхцөл байдлыг хянах чадамж гэж” (MAIER, 1990); “Улс төрийн төлөвшил ба тэсвэр, хүний нөөц, эдийн засгийн бүтэц ба чадавх, технологийн ур чадвар, үйлдвэрлэлийн бааз, байгалийн нөөцийн хүртээмж, эцэст нь цэргийн хүч чадлыг зохистой хослуулсан цогц ойлголт гэж” (“A Maritime Strategy for India”, 1996); “Тухайн улс олон талт аюул заналын өмнө өөрийн ард иргэдийн сайн сайхан байдал, улс төрийн оршин тогтнолыг хамгаалах чадавхыг хэмжиж болохуйц түвшинд байлгахыг хэлнэ. Энэ нь төрийн бодлогын бүх хэрэгслийг засаглалын хүрээнд тэнцвэржүүлэн ашиглах замаар хэрэгждэг бөгөөд гадаад хүчин зүйлээс хамааран дэлхийн аюулгүй байдлын түвшинд ч тэлэгдэж болно гэж” (Paleri, 2008) тус тус тодорхойлж байжээ.

Тэгвэл Набил Фахни² 2026 оны дөрөвдүгээр сард “Үндэсний аюулгүй байдлын хувьсал ба түүний бүс нутгийн болон дэлхийн түвшний агуулга” гэсэн

² Набил Фахни нь Египет улсын гадаад хэргийн сайд асан, Арабын лигийн ерөнхий нарийн бичгийн дарга болох гэж байгаа эрхэм байна. Тэрбээр “The evolution of National Security and its regional and global context” өгүүллийг нийтэлсэн байна.

өгүүлэлдээ “Үндэсний аюулгүй байдал нь хэзээ ч статик зарчимтай байгаагүй, байнга хувьсан өөрчлөгдөж ирсэн. Өөрөөр хэлбэл: цаг хугацааны явцад улс орны улс төрийн тогтолцоо оршин тогтнох, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахаас эхлээд эдийн засгийн хөгжил, технологийн чадавх, мэдээллийн бүрэн бүтэн байдал, нийгмийн эв нэгдэл, тэр ч байтугай хангамжийн нийлүүлэлтийн сүлжээ хамрах болж өргөжсөн” гэжээ. Мөн тэрээр улс орнуудыг “Өнөөдрийн урьдчилан таамаглаж болох, дүрэмд суурилсан дэг журмаас ирээдүй илүү ээдрээтэй, хоорондын зөрчилдөөнтэй тогтолцоо руу шилжих боллоо. Үүнд: том гүрнүүд шууд мөргөлдөөнөөс зайлсхийж, бүс нутгийн нөлөөлөл, кибер ажиллагаа, эдийн засгийн албадлага, холбоотнуудаар дамжуулан өрсөлдөх шинжийг агуулах боллоо. Үүний үр дүнд дэлхий олон туйлт (төвт) хуваагдмал байдалтай, олон улсын институци сул дорой, аюулгүй байдлын сорилт, эрсдэл илүү өргөн хүрээний буюу хосолмол, саарал орчинд явагдах боллоо” гэж олон улсын аюулгүй байдлын орчинтой холбон дүгнэсэн байдаг.

Дээрх тодорхойлолтууд цаг хугацааны хувьд аюул заналын өөрчлөлттэй уялдаж “Үндэсний аюулгүй байдал” гэсэн ойлголт хэрхэн хувьсаж байгааг харуулж байна. Эдгээр өөрчлөлтийг судлаачид янз бүрээр тайлбарласан байдаг. Тухайлбал: Набил Фахни Уламжлалт буюу Вестфалийн тогтолцооны үе, дэлхийн I, II дайны үе, хүйтэн дайны үе, улс биш тоглогчид нэмэгдэж орж ирсэн үе, даяаршил болон техник, технологийн хөгжлийн үе гэсэн таван үечлэлд хуваан авч үзжээ. Эдгээр үечлэлд үндэсний аюулгүй байдлын хувьслын онцлогийг авч үзвэл:

1. *Уламжлалт (Вестфалийн тогтолцоо) үе.* Тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг чухалчилсан төр төвтэй, цэрэг улс төрийн аюулгүй байдлын нөхцөлөөр тодорхойлогдож байсан үе;
2. *Дэлхийн дайны үе.* Улсын хэмжээний цогц асуудал болж, хүчирхэг улс орнуудын хоорондын өрсөлдөөнөөр тодорхойлогдож эхэлсэн үе;
3. *Хүйтэн дайны үе.* Дайнд урьдчилан бэлтгэх, цэргийн холбоотон бий болгох замаар хүч хэрэгслээ зузаатгах, цөмийн тэнцвэрт байдал, тагнуулын өрсөлдөөнд суурилж байсан үе. Энэ үед хүйтэн дайны төгсгөл хүртэл үндэсний аюулгүй байдлыг гол төлөв төрийн бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал, цэрэг улс төрийн хүчин чадал, гадаад улс орны зүгээс дайны аюул үүснэ гэсэн нөхцөлтэй холбон ойлгож байв. Түүнчлэн үндэсний аюулгүй байдлын судалгаанд дараах асуудлууд зонхилж байв. Үүнд: Төр бол аюулгүй байдлын цорын ганц субъект, цэргийн хүч бол аюулгүй байдлын гол хэрэгсэл, аюул нь гадаад орчноос үүдэлтэй гэж үздэг реализмын парадигм давамгайлж байсан. Гэвч XX зууны сүүлийн жилүүдэд олон улсын орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд үндэсний аюулгүй байдлын ойлголтыг улам саармаг болгож эхэлсэн;
4. *Хүйтэн дайны дараах үе буюу улс биш тоглогчид үндэсний аюулгүй байдлын харилцаанд орж ирсэн үе.* Тухайлбал: АНУ-д болсон 2001 оны есдүгээр сарын 11-ний террорист халдлага нь улс биш тоглогч үндэсний хэмжээний хохирол

учруулж болохыг харуулсан. Мөн хоёр туйлт системийн нуран уналт, олон улсын харилцааны тогтолцооны өөрчлөлт нь уламжлалт аюулгүй байдлын ойлголтыг дахин авч үзэх шаардлагыг бий болгосон. Дэлхийн улс орнууд үндэсний аюулгүй байдлын тухай ойлголтыг өргөжүүлж, терроризмтой тэмцэх, санхүү болон улс орны хилийн хяналтыг нэмж багтаасан байдаг. Энэ үед эдийн засгийн хямрал, мэдээллийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчны доройтол зэрэг уламжлалт бус аюул заналууд нэмэгдсэн нь үндэсний аюулгүй байдлын тухай ойлголтод тусгалаа олсон байна;

5. Даяаршил болон техник, технологийн хөгжлийн үе. Энэ үед улс орнуудын харилцан хамаарал, бараа үйлчилгээний нийлүүлэлтийн сүлжээ, санхүүгийн зах зээл, мэдээллийн урсгал зэргийг урьд өмнө байгаагүй хэмжээнд холбож, үндэсний аюулгүй байдлыг дан ганц улсын хүрээнд хангах боломжоос хальж улс дамнасан сүлжээг бий болгосон. Энэ үед үндэсний ба олон улсын аюулгүй байдлын зааг бүдгэрч, аюулгүй байдлын бодлого нийгмийн байгуулалтын олон түвшнийг хамарсан засаглал (multilayered governance) руу шилжсэн гэж зарим судлаач үздэг. (David Held and Anthony McGrew, 2011)

Набил Фахнигийн гаргасан үечлэл дээр нэмж дурдвал 1994 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “хүний аюулгүй байдал” гэсэн шинэ парадигмыг дэвшүүлсэн. Үүнтэй уялдуулж хүний аюулгүй байдлын парадигм буюу иргэн төвтэй ойлголт Үндэсний аюулгүй байдлын ойлголтод нэмэгдэж орж ирсэн. Үүнээс үүдэлтэй хувь хүний амь нас, эрүүл мэнд, хүнсний хангамж, эдийн засгийн баталгаат байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, нийгмийн оролцоо зэрэг нь үндэсний аюулгүй байдлыг хангахад чухлаар тавигдах болж ирсэн. Энэ нь аюулгүй байдлыг зөвхөн төрийн батлан хамгаалах буюу уламжлалт ойлголтын асуудал бус хүн төвтэй хөгжлийн асуудал гэж үзэх шинэ хандлагыг бий болгожээ.

Үндэсний аюулгүй байдлын хувьсалд XXI зуун гарсаар “Resilience” буюу “Үндэсний сөрөн тэсвэрлэх” парадигм бий болсон. Энэ нь XXI зуунд бий болсон, бий болж байгаа кибер аюул, мэдээллийн дайн, улс орнуудын эрчим хүчний хомсдол, хамаарал, цар тахал, нийлүүлэлтийн сүлжээний доголдол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг нийлмэл, хосолсон, олон талт аюул заналууд нэмэгдсэнээр уламжлалт аюулгүй байдлын тогтолцоо хангалтгүй байгааг илэрхийлэх болж ирсэн. Ийм нөхцөлд улс орнуудын аюулгүй байдлын бодлого буюу үзэл баримтлал Үндэсний сөрөн тэсвэрлэх парадигм руу анхаарлаа хандуулж эхэлсэн байна.

Хоёр. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нь

Өнөөдөр үндэсний аюулгүй байдлын судалгаанд Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь салбар дундын уялдаа, нийгэм буюу төр-хувийн хэвшил-иргэний хамтын ажиллагаа, нийгмийн институцийн тасралтгүй ажиллагаа, нийгмийн эв нэгдэл, мэдээллийн дархлаа зэрэг хүчин зүйлийг нэгтгэсэн үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын тогтолцоо (national resilience system) хэлбэрээр хөгжиж байна.

Үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлал нь аюулгүй байдлыг зөвхөн хамгаалах бус тухайн үндэсний аюулгүй байдлын нөхцөлд үйл ажиллагааны үндсэн чиглэлээ алдахгүйгээр дасан зохицох, хувьсан шинэчлэх чадамж бүхий динамик систем гэж үзэх шинэ ойлголт юм.

Эхэндээ resilience (уян хатан чанар) гэдэг нэр томьёо нь техникийн салбаруудад тодорхой физик үзэгдэл, үйл явцын шинж чанар (жишээлбэл, материал эсвэл механизм нь энерги хуримтлуулж, эвдрэл гэмтэлгүйгээр их хэмжээний ачааллыг тэсвэрлэх чадвар) хэлбэрээр түгээмэл болсон. Хожим нь сэтгэл судлал (сөрөг нөлөөлөл эсвэл дарамт, дарангуйллын дор зан төлөвийг өөрчлөхгүй байх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хадгалахад тусалдаг хувь хүний шинж чанаруудын нэг), экологи (байгалийн болон хүний үйлдэлтэй гамшгийн хор уршгаас нөхөн сэргэх экосистемийн чадвар), нийгмийн харилцаанд ашиглагдаж эхэлсэн. Уян хатан тэсвэртэй чанар гэдэг ойлголт нь олон талт, салбар бүрт хэрэглэгддэг бөгөөд өөр өөр утгатай. Жишээлбэл: “материалын уян хатан чанар”, “хүний сэтгэл зүйн тогтвортой байх чадвар”, “байгалийн гамшигт тэсвэртэй дэд бүтэц”, “террорист аюул заналхийлэлд автагдахгүй нийгэм”, “кибер халдлагаас хамгаалагдсан, тогтвортой үйл ажиллагаа явуулах чадвартай цахим систем” гэсэн нэр томьёог нийтлэг хэрэглэдэг. “Уян хатан чанар” гэсэн ойлголт нь салбар салбарын хэллэгт хоорондоо холбоогүй огт өөр агуулгатай боловч хэллэг бүрд тогтвортой “өөрийн чиг үүрэг, чанарыг гадны нөлөөн доор хадгалах” гэсэн утгыг агуулж байна.

Нэр томьёоны тодорхойгүй байдлаас үүдэх төөрөгдлийг арилгах үүднээс, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой судалгаа болон бодлогын баримт бичигт “үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги” хэмээх ойлголтыг зөвхөн газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, хөгжлийг хамгаалах хүрээнд хязгаарлахгүйгээр, харин үндэсний болон нийгмийн бүлгүүдийн онцлог, үнэт зүйлс, улс төрийн зохион байгуулалт, нийгмийн тогтвортой оршин тогтнохуйг бүхэлд нь хамарсан өргөн утгаар ашиглах шаардлагатай ойлголт юм.

НҮБ-ын Гамшгийг бууруулах олон улсын стратегийн (UNISDR) гарын авлагад нийтлэгдсэн “Гамшгийн үеийн хариу арга хэмжээний чадавх” тодорхойлолтод “Систем, нийгмийн бүлэг, нийгэм өөрийн үндсэн бүтэц, үйл ажиллагааг хадгалах замаар, аюулын нөлөөллийг цаг тухайд нь, үр дүнтэй эсэргүүцэх, сөрөг нөлөөг арилгах, дасан зохицох, нөхөн сэргээх чадавхыг хэлнэ” гэсэн байна.

Карл Фолке “Resilience” өгүүлэлдээ “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” гэдгийг урьдчилан тооцоолсон болон гэнэтийн өөрчлөлтийн үед үүсэж болзошгүй хүндрэл, сорилтыг даван туулж, үндэсний хөгжлийн чиглэл, замналаа алдагдуулахгүйгээр тогтвортой үргэлжлүүлэх чадамжийг төлөвшүүлэх үйл явц хэмээн тодорхойлсон байдаг. Тэрээр цаашлаад “*Resilience thinking*” буюу “Сөрөн тэсвэрлэх сэтгэлгээ” гэсэн ойлголтыг дэвшүүлж, түүнийг үндэсний аюулгүй байдлын судалгаатай холбон тайлбарласан байдаг. (Folke, 29 September 2016)

Сөрөн тэсвэрлэх сэтгэлгээ нь улс, нийгмийн тогтолцоо гадаад болон дотоод аюул, заналхийлэл, гамшиг, хямралын үед орших чадвараа хадгалах, дасан зохицох, шаардлагатай тохиолдолд бүтцийн шинэчлэл хийх замаар тогтолцоог шинэ түвшинд гаргах боломжийг судалдаг байна. Харин бүтээлч сэтгэлгээ нь хувь хүн болон хамт олон шинэ санаа, шинэлэг шийдэл, өөр хувилбаруудыг бий болгох чадварт илүү чиглэдэг. Энэхүү хоёр ойлголт хоёулаа уян хатан байдал, нөхцөл байдлыг шинээр харах чадвар дээр огтлолцдог боловч зорилго, хэрэглээний хүрээ нь ялгаатай. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын онолын хувьд сөрөн тэсвэрлэх сэтгэлгээ нь үндэсний оршихуй, нийгмийн тогтвортой байдал, институцийн үр ашигтай ажиллагааг хадгалах суурь зарчим болдог. Харин бүтээлч сэтгэлгээ нь шинэчлэл, өөрчлөлтийн боломжийг нээж, сорилтыг даван туулах арга замыг өргөжүүлэх дэмжих хүчин зүйл юм.

Дэлхийн хүрээлэн буй орчны доройтол, улс орнуудын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал либерал чиг баримжаанаас реалист чиглэл рүү эргэн шилжиж буй байдал, түүний үр дагавар, ашигт малтмалын болон цэнгэг усны хомсдол, технологийн хөгжил, цар тахал зэрэг бусад хүчин зүйл нь үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт болон түүний хамрах хүрээг улам тэлж байна. Энэ нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг зөвхөн төр дангаараа хангах боломж хумигдаж, харин нийгмийн бүх гишүүд өөрийн үнэт зүйлээ хамгаалах, боломжит бүх чадавхаа сайн дурын үндсэн дээр дайчлан оролцох шаардлага бий болжээ. Ийм олон талт, огцом өөрчлөгдөж буй аюулгүй байдлын орчинд улс үндэстэн аюулгүй байдлаа хангахад улам бүр төвөгтэй болжээ. Эрдэмтдийн үзэж буйгаар үндэсний сөрөн тэсвэрлэх зарчмуудыг тусган, шинэ нөхцөлд нийцсэн үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, стратеги боловсруулах шаардлага тулгарч байна.

Үндэсний аюулгүй байдал судлалын онолын суурь болох системийн онолыг хөгжүүлэхэд сөрөн тэсвэрлэх сэтгэлгээ чухал ач холбогдолтой. Сөрөн тэсвэрлэх сэтгэлгээг үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлалд тусгаснаар үндэсний аюулгүй байдлыг хангах үйл явц үр дүнд хүрэх болно. Үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлалын талаарх ойлголтыг судлаачид өөр өөр байр сууринаас тайлбарладаг. Үүнийг нэг ойлголтод хүргэх нь чухал юм. Тиймээс Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь тогтоон барих хүчний нэг багана (Resilience as Pillar of Deterrence) (Will, September 16, 2025), Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь бүх нийтээрээ батлан хамгаалах загвар (the Total Defense Model) (security, 2024), Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь хариуцлагыг шилжүүлэх неолиберал арга зам (Resilience as Neoliberal Burden-Shifting) (Ridley,), Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох цогц систем (Complex Systems and Climate adaptation) (Amineh Ghorbani, Saba Siddiki, Giangiacomo Bravo., 06 March 2023) зэрэг салбар бүрт хэрэглэгддэг ойлголт юм.

Үндэсний аюулгүй байдал гэдэг нь тухайн улсын бүрэн эрхт байдал, иргэдийн аюулгүй оршин тогтнох нөхцөл, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжил, үндэсний ашиг сонирхлыг гадаад, дотоод аюулаас хамгаалах цогц чадамж, бодлого,

үйл ажиллагааны үр дүн гэж тодорхойлон үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд төр өөрийн төрийн байгуулалт, түүний хүч хэрэгслийг ашиглах нь зүйн хэрэг.

Харин Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь хоорондоо уялдаа холбоотой олон дэд тогтолцооноос бүрдэх бөгөөд тэдгээр нь үндэсний үнэт зүйлсийг хамгаалах, хадгалах, бэхжүүлэх, улмаар үндэсний хөгжлийг хангахад чиглэсэн нийтлэг зорилготой. Энэ тогтолцоо нь хууль тогтоомжийн хүрээнд үндэсний аюулгүй байдлын зорилтуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн болон бусад байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг зохион байгуулалтын цогц юм. Түүнчлэн, Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь төвлөрсөн ба тодорхой эрх зүйн хүрээнд зохион байгуулсан байдаг бол үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хангах тогтолцоо нь уян хатан, нийгмийн болон нийгмийн бүлгийн үнэт зүйлс, соёл, итгэл үнэмшил, итгэлцэл дээр суурилсан сайн дурын үйл явц юм. Үүгээрээ энэхүү үндэсний аюулгүй байдал, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хангах тогтолцооны ялгаа оршиж байдаг.

Үүнээс төвлөрсөн зохион байгуулалттай тогтолцооны онцлог нь үйл ажиллагааны хүчин чармайлтаа төвлөрүүлж чаддаг, тогтолцооны элемент хоорондох гүйцэтгэх үүрэг, хариуцлага тодорхой байдаг нь таамаглах боломжтой нөхцөлд илүү тогтвортой байх боломж олгодог. Гэхдээ тогтолцоог хөгжүүлэх, ялангуяа шинэ шинж чанарыг олж авахад бэрхшээлтэй. Ийм тогтолцоо урьдчилан таамаглах боломжтой орчин болон төлөвлөгөөт ажил, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд илүү үр ашигтай байдаг. Гэсэн хэдий ч үндэсний аюулгүй байдлыг хангах уламжлалт тогтолцоонд эрх мэдлийн хэт төвлөрөл, шаталсан бүтэц давамгайлдаг нь доод нэгжүүд болон дэд тогтолцоонуудтай уялдаа холбоог сулруулж, тогтолцооны бусад элементийн хоорондын харилцан үйлчлэлийг ч мөн хязгаарладаг. Ийм тогтолцоо тогтвортой боловч уян хатан чанар багатай тул гадаад, дотоод орчны огцом өөрчлөлтийн үед дасан зохицох чадвар нь хангалтгүй байдаг. Иймээс тогтолцооны уян хатан байдлыг нэмэгдүүлэх, гэнэтийн гамшиг, хямралт байдалд илүү үр ашигтай хариу үйлдэл үзүүлэхийн тулд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх шаардлага чухлаар тавигдах болоод байна.


Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь төрийн байгууллагуудаар дамжуулан төр, нийгэм, иргэн бүрийг хамгаалах үндсэн зорилготой бол үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн үүрэг, хариуцлагын тодорхой хэсгийг олон нийт, байгууллага, хувь хүнд шилжүүлж, тэд өөрсдөө аюул заналхийллийн нөхцөлд бие даан бэлтгэгдэж, хариу арга хэмжээ авах чадвартай байхыг шаарддаг онцлогтой. Мөн Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны байгууллага, нэгжүүд “дээрээс доош” гэсэн удирдлагын тогтолцоотой (засаг гол эрх мэдлийг төвлөрүүлдэг), харин үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцооны удирдлага хамтын (эрх мэдлийг хуваарилдаг), санаачилга “доороос дээш” зарчмын дагуу явагддаг. Жишээ нь: төрийн албан хаагчид төрийн байгуулалтын тогтолцоо, түүний үйл ажиллагааны зарчим, шийдвэр гаргалтын үе шат, журам, хугацааны талаар бүрэн, зөв ойлголттой байх шаардлагатай. Үүний нэгэн адил иргэд төрийн

байгууллагын шийдвэр хэрхэн, ямар үндэслэл, ямар журмаар гардаг тухай мэдлэгтэй байх нь төр–иргэний харилцааны ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Мөн төрийн албан хаагчид хувийн хэвшлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн орчин, түүний хэрэгжилт, бизнесийн практик, орлого зарлагын бүтэц, татварын тогтолцоо, тайлагналын процесс зэрэг үндсэн ойлголтыг мэддэг байх нь зүйтэй. Ийм мэдлэг, ойлголт нь төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн хоорондын итгэлцэл, харилцан ойлголцлыг бүрдүүлэх суурь нөхцөл болдог бөгөөд төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, бодит хэрэгцээнд нийцсэн байдлаар хүргэх эхний алхмын нэг юм.

Ерөнхийдөө, үндэсний аюулгүй байдлыг хангах болон үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хангах тогтолцоо хоорондын уялдаа холбоо чухал юм. Тэдгээр нь харилцан үйлчилж, бие биеэ нөхөж чаддаг байх шаардлагатай. Ингэснээр үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь уян хатан болж, хөгжих шинж чанарыг олж авдаг бөгөөд энэ нь орчин үеийн аливаа аюул заналхийллийн эсрэг тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх боломж олгоно (Зураг 1).

Зураг 1. Үндэсний аюулгүй байдлыг хангах болон үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо хоорондын уялдаа холбоо



Гурав. Үндэсний аюулгүй байдлыг хангахад үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлалыг ашиглах нь

Орчин үеийн аюулгүй байдлын орчинд хосолмол (hybrid) заналхийллийг илрүүлэх, тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх нь хамгийн хүндрэлтэй бэрхшээл, эрсдэл болж байгааг өмнө тэмдэглэсэн. Уламжлалт болон уламжлалт бус аюулыг хослуулсан эдгээр заналхийлэл нь кибер орчин, мэдээллийн орон зай,

эдийн засаг, нийгмийн сэтгэл зүй зэрэг олон талбарт нэгэн зэрэг нөлөөлснөөр үндэсний аюулгүй байдалд цогцоор нь заналхийлэл учруулдаг. Ийм нөлөөлөл нь улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн аюулгүй байдал, нийгмийн эв нэгдэл, төрийн институцийн чадавх зэрэг үндэсний аюулгүй байдлын тулгуур элементийг сулруулж, улс орны тогтвортой хөгжилд эрсдэл бий болгодог.

Хосолмол заналхийллийн уялдаа холбоотой шинж чанар нь улс төрийн орчин (мэдээллийн манипуляци, нийгмийн сэтгэл зүйн нөлөөлөл), эдийн засаг (нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, санхүүгийн дарамт), кибер орчин (цахим мэдээллийн системийн доголдол, халдлага), нийгмийн тогтвортой байдал (олон нийтийн төрд итгэх итгэл сулрах, нийгмийн хуваагдал), дэд бүтэц (эрчим хүч, харилцаа холбоо, тээврийн системийн доголдол) зэрэг салбарт зэрэгцээ байдлаар нөлөөлдөг. Энэхүү нөлөөлөл нь хурдан хугацаанд өрнөх боломжтой тул төр, нийгэмд ноцтой аюул учруулах болоод байна.

Хосолмол заналхийлэлд үр дүнтэй хариу арга хэмжээ авахын тулд санхүүгийн нөөц (өндөр өртөгтэй хамгаалалтын систем, зарим тохиолдолд бие даасан санхүүгийн системийн хэрэгцээ, кибер аюулгүй байдлын шаардлага хангасан дэд бүтэц), техникийн чадавх (мэдээллийн технологи, мониторинг, дата шинжилгээ), хүний нөөц (хиймэл оюун хөгжиж, түүнийг өргөнөөр ашиглаж байгаа энэ цаг үед мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчдийн баг, нийгмийн капитал), институцийн уялдаа (төрийн байгууллагуудын шуурхай зохицуулалт), олон нийтийн оролцоо (мэдээллийн дархлаа, сэтгэл зүйн тогтвортой байдал) зэрэг хүчин зүйл зайлшгүй шаардлагатай. Гэвч эдгээр нөөц, боломж хөгжиж буй улсын төр, түүний засаглалын институцид хязгаарлагдмал байдаг. Энэ нь үндэсний аюулгүй байдлыг хангахад томоохон хүндрэл үүсгэдэг. Тиймээс энэхүү хүндрэлийг даван туулахад үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх чухал ач холбогдолтой.

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь улс орнуудын нийгмийн институцийн бүтэц, аюулгүй байдлын орчин, түүхэн туршлага, улс төрийн уламжлал, үндэсний үнэт зүйлс, аюулгүй байдлын талаарх нийтлэг ойлголт, аюул заналд хариу үзүүлэх дадал, тухайн үндэсний соёл иргэншлийн бусад онцлог зэрэг хүчин зүйлээс хамааран өөр өөрөөр хөгжсөн байдаг.

Үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлалын үндэслэл, гол чиглэлүүдийн тодорхойлолт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, институцийн зохион байгуулалт, түүний зохицуулалтын хүрээний талаар улс орон, олон улсын байгууллагууд анхаарлаа хандуулах болсон. Үүнд: Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын тогтолцоог бүрдүүлэх, түүнийг ашиглах албан ёсны баримт бичгүүдийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Заримаас нь дурдвал:

1. НАТО-гийн “Resilience Baseline Requirements” (Resilience) баримт бичигт гишүүн улсуудын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хангахад засаглалын тасралтгүй ажиллагаа, эрчим хүчний аюулгүй байдал, хүнсний хангамж, эрүүл мэндийн систем, харилцаа холбоо ба мэдээллийн дэд бүтэц, тээвэр

логистик, хүн амын хамгаалагдсан байдал гэсэн долоон үндсэн шаардлагыг тавьдаг. Хэрэгжилтийг хангахад институцийн зохион байгуулалт, хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог хангах замаар холбоотны цэргийн ажиллагааг дэмжих зорилгыг агуулсан байна.

2. Европын Холбооны “Societal Resilience” (Union, 2023) хандлага нь нийгмийн тогтвортой байдал, ардчиллын институцийн бат бөх байдал, мэдээллийн орчны дархлаа, дижитал аюулгүй байдал, эрсдэлийн интеграцчилсан менежмент зэрэгт төвлөрсөн байна. Энэ хандлага нь тус холбооны онцлог бүхий олон түвшний засаглал, оролцоонд суурилсан бодлогыг чухалчилжээ.
3. АНУ-ын Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги (white house, 2025) нь нийгэм бүхэлдээ оролцсон, эрсдэлд суурилсан, системийн хандлагад тулгуурлаж, засаглал, нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн бүх түвшинд үндэсний чадавхыг бэхжүүлэх зорилготой. Энэхүү стратеги нь цаг хугацааны хувьд хурдтай өөрчлөгдөж буй эрсдэлийн орчин, үүнд: уур амьсгалын өөрчлөлт, технологийн саатал, сөрөг нөлөө, цар тахал, геополитикийн өрсөлдөөнд хариу үйлдэл үзүүлэхдээ уян хатан байдал, тэгш хүртээмж, орон нутаг болон олон нийтийг чадавхжуулахыг онцолсон байдаг.
4. Япон (Secretariat) болон Австрали нь (Committee, 2023) “Whole of Government /Whole of Society” зарчим дээр тулгуурлан Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хөгжүүлж байна. Чадавхыг хөгжүүлэхдээ Япон нь хүний амь насыг хамгаалах, төрийн удирдлага болон нийгмийн, эдийн засгийн тогтолцоо тогтвортой байх, иргэдийн өмч, олон нийтийн дэд бүтэц, байгууламжид учрах хохирлыг бууруулах, сэргээн босголт түргэн шуурхай байх зэрэг зарчмыг баримталж байна. Харин Австрали нь гамшгийн үр дагаврыг арилгах хандлагаас эдийн засгийн салбарт сөрөн тэсвэрлэх сэтгэлгээг бүрдүүлэхэд санаачилга гаргаж эхэлсэн байна.

Эдгээр олон улсын байгууллага, улсын туршлага нь төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм, орон нутгийн засаг захиргаа зэрэг бүхий л түвшний оролцооны уялдааг нэгтгэснээр онцлог юм.

Эндээс улс орны аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үндэсний сөрөн тэсвэрлэх бодлогоо тодорхойлж, хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх нь засаглалын үүрэг байх болно. Дээрх олон улсын байгууллага, гадаад улсуудын туршлагаас авч үзэхэд Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх загварууд нь системийн уялдаа, институцийн чадавх, олон нийтийн оролцоо, амин чухал дэд бүтцийн хамгаалалт, эрсдэлд суурилсан уян хатан тогтолцоог хөгжүүлэхдээ төвлөрч байна. Энэ нь дараах нийтлэг шинжийг агуулж байна. Үүнд: бодлого боловсруулалт, түүний хэрэгжилтийг хангахад нийгмийн бүх түвшнийг хамарсан системийн хандлага, эрсдэлд суурилсан, уян хатан, дасан зохицох шинж чанартай тогтолцоо, төрийн институцийн чадавх болон засаглалын тогтвортой үр дүнтэй ажиллагаа, шаардлагатай дэд бүтэц, нийгмийн суурь системүүдийг хамгаалах нийтлэг

зорилго, технологи, мэдээллийн орчны аюулгүй байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлт, цар тахал зэрэг эрсдэлийг хослуулан тооцоход оршжээ. Эдгээрийг хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог тогтмол хангаж байхад анхаарах нь зүйн хэрэг байна.

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хангах тогтолцоо нь тухайн улсын хэрэгцээ шаардлага, олон улсын байгууллага болон холбоонд гүйцэтгэж буй оролцоо, бусад хүчин зүйлээс хамааран өөр өөр байдаг. Улс орнуудын энэ чиглэлд хуримтлуулсан туршлага нэн ялгаатай бөгөөд бүх улсын хэрэгцээнд нийцэх “нэг загвар” гэж байдаггүй. Зарим улсад тохирсон үр дүнтэй тогтолцоо, арга хэрэгслүүд бусад улсын хөгжлийн онцлог, нөхцөлд тохирохгүй байж болно. Ийм нөхцөлд бусад улсын тэргүүн туршлага, тэргүүлэх олон улсын байгууллагуудын зөвлөмжийг судлан ашиглах нь Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, улс төр нийгмийн хөгжлийн өвөрмөц онцлогт нийцсэн дэлхийн шилдэг туршлагыг нутагшуулах боломжийг бүрдүүлнэ. Үүнтэй зэрэгцэн шинжлэх ухааны үндэслэл, судалгаа, шинжилгээнд тулгуурлан үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлал, загвар, механизмыг боловсруулах нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Монгол Улсад Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хөгжүүлэхэд дараах чиглэлд анхаарах шаардлага байна. Үүнд:

- Салбар хоорондын уялдаа, давхардсан менежмент (үүний дотор эрсдэлийн асуудлыг давхар оруулсан)-ийн удирдлагыг цэгцлэх системийн сэтгэлгээ;
- Үндэсний үнэт зүйлс, уламжлалыг хадгалж хөгжүүлэх замаар соёлын дархлааг Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын бүрэлдэхүүн болгох;
- Хот хөдөөгийн болон нийгмийн бусад бүлэг хоорондын ялгааг бууруулах замаар нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, эмзэг бүлгийг хамгаалах;
- Улсын мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан бодлого боловсруулах, шийдвэр гаргах, түүний хэрэгжилтийг хангах;
- Төр-хувийн хэвшил-иргэдийн хамтын ажиллагааг төлөвшүүлэх;
- Бүс нутгийн тогтворгүй байдлын нөлөөллийг бууруулахад оролцох, нөлөөг тооцох;
- Гамшгийн эрсдэлийн менежменттэй нийгмийн амьдралыг уялдуулах зэрэг байна.

Түүнчлэн үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хөгжүүлэхэд төрийн институцийн чадавхын хязгаарлалт, дата, судалгааны суурь түвшин сул, нийслэл дэх хүн амын хэт төвлөрөлт, цэвэр усны хязгаарлагдмал нөөц болон суурин газрын агаарын бохирдол, дотоодын үйлдвэрлэл болон хангамжийн сүлжээ сул, хөрш улсуудаас хамааралтай байдал, орон нутгийн хөгжлийн түвшин тааруу, төрийн байгууллага иргэд хоорондын итгэлцэл сул зэрэг нь бэрхшээл дагуулсаар байгаа болно.

Харин Монгол Улс нийгмийн хувьд сөрөн тэсвэрлэх чадавхыг хөгжүүлэхэд дараах давуу талтай гэж үзэж болно. Үүнд: соёл иргэншлийн хувьд Монгол гэсэн нэрээрээ бахархах түүхтэй, бусад үндэстний соёлыг бага гадуурхдаг, хүлээн зөвшөөрдөг, нийгмийн эв нэгдэл чухал гэдгийг мэддэг, жилийн дөрвөн улиралд дасан зохицож амьдарч чаддаг нүүдлийн ахуй, амьдралтай иргэдтэй, хүн амын олонх ахуй амьдралын хувьд хэт өндөр шаардлагыг тавьдаггүй. Мөн төрийн үйл ажиллагаанаас үл хамааран бие даасан амьдрах чадвар залуучуудад давамгайл. Тиймээс Монгол эх орноо гэсэн үзэл суртлыг суулгах, нийгмийн бүлэглэл, цаашлаад Монгол хүн гэсэн нийгмийн идэвхтэй гишүүн болгон үүрэг, хариуцлагыг авч явах боломж монгол хүн, Монголын нийгэмд байна гэж үзэж байна.

Дээрх онцлог, давуу талыг харгалзан, системийн уялдааг хангах загварчлалыг бий болгох, шалгаж, туршиж Монгол Улсын Үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлалыг Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоотой уялдуулан боловсруулах, Монголын төр засаг, иргэд, олон нийт, нийгмийн бүх бүлэг, давхарга хамтран хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг бий болгожээ.

Монгол Улсын Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд иргэдийн боловсрол, эрүүл мэнд, эх оронч сэтгэлгээнээс гадна орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлого, эдийн засгийн чадавхтай аж ахуйн нэгж болон иргэдийн үүрэг, оролцоо чухал юм. Нөгөөтээгүүр, Монгол Улсын Үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлалыг боловсруулахад төрийн цэргийн байгууллагад өргөн хэрэглэгддэг команд штабын сургуулийн арга зүйг ашиглах явдал гэж үзэж байна. Энэхүү арга зүй нь нөхцөл байдлыг бүхэлд нь нэгд, системийн уялдаа холбоог хангах шаардлагыг загварчлан боловсруулах, *хоёрт*, инновац, технологийн шийдлийг үндэсний сөрөн тэсвэрлэх бодлогод интеграцчилах, *гуравт*, нийгмийн давхарга, бүлгүүдийн ялгааг бууруулах, *дөрөвт*, соёлын дархлаа, нийгмийн эв нэгдэл, уламжлалт зохицуулалтын механизмыг тогтолцооны хувилбаруудад суулгах, бий болгох, үнэлэх, сонгон нэвтрүүлэх үйл явцыг шат дараатайгаар оновчтой зохион байгуулах зэрэг практик ач холбогдолтой.

Дүгнэлт

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь Үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо юм. Гэвч эдгээр хоёр тогтолцоо нь удирдлага, зохион байгуулалтын зарчмаараа тодорхой хэмжээнд ялгаатай. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь төрийн байгууллагуудын чадавх, төвлөрсөн шийдвэр гаргалтад тулгуурласан дээрээс доош чиглэсэн босоо удирдлагын бүтэцтэй. Харин Үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо нь төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, орон нутгийн оролцоог нэгтгэсэн доороос дээш чиглэсэн санаачилга, хамтын оролцоонд илүү түшиглэгдгээрээ онцлогтой байна.

Хосолмол заналхийллийн эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авахад улс орнууд санхүү, техник болон хүний нөөцийн өндөр чадавх шаарддаг боловч ихэнх улс оронд эдгээр нөөц хязгаарлагдмал хэвээр байна.

Иймд хосолмол заналхийллийн эрсдэлийг бууруулах, түүнтэй тэмцэх бодлого нь системийн сэтгэлгээ, иргэд олон нийтийн олон талт оролцоо, институцийн уялдаа, мэдээллийн дархлаа, инновацад суурилсан байх шаардлагатай ажээ. Энэ шаардлагыг хангахад Үндэсний сөрөн тэсвэрлэх үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо чухал үүрэгтэй болсныг харуулж байна.

Монгол Улсад Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хөгжүүлэхэд салбар хоорондын уялдааг хангаж, үндэсний үнэт зүйлс, уламжлалыг хадгалж хөгжүүлэх, нийгмийн бүлгүүд хоорондын ялгааг бууруулах замаар, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан бодлого боловсруулах, шийдвэр гаргах, түүний хэрэгжилтийг хангах, төр-хувийн хэвшил-иргэдийн хамтын ажиллагааг төлөвшүүлэх, дэлхийн бүс нутгийн тогтворгүй байдлын нөлөөллийг бууруулахад оролцох, нөлөөг тооцох, гамшгийн эрсдэлийн менежменттэй нийгмийн амьдралыг уялдуулах хэрэгцээ байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Walter Lippmann, US Foreign Policy, Shield of the Republic, Boston Mass, 1943.
- H.D.Lasswell, National Security and Individual Freedom, McGRAW-HILL, 1950.
- Arnold Wolfers, National Security As An Ambiguous Symbol, edited Discord and Collaboration, Baltimore, 1962.
- Harold Brown, National Security Thinking about defense and foreign policy in a dangerous world, 1983.MAIER, CHARLES S. Peace and security for the 1990s. Unpublished paper for the MacArthur Fellowship Program, Social Science Research Council, 12 June 1990.
- Proceedings of Seminar on «A Maritime Strategy for India» National Defence College. 1996.
- Paleri, Prabhakaran . National Security: Imperatives And Challenges. New Delhi. 2008.
- David Held and Anthony McGrew, The Great Globalization Debate: An Introduction. Page 12.
- Resilience- The ability of a system, community or society exposed to hazards to resist, absorb, accommodate to and recover from the effects of a hazard in a timely and efficient manner, including through the preservation and restoration of its essential basic structures and functions. 2009 UNISDR Terminology on Disaster Risk Reduction https://www.preventionweb.net/files/7817_UNISDRTerminologyEnglish.pdf?startDownload=true
- Carle Folke, Resilience, Oxford Academic, 29 September 2016, <https://academic.oup.com/edited-volume/61750/chapter-abstract/542846717?redirectedFrom=fulltext>
- Will, Cohesion, Resilience, and the Wars of the Future, Commentary by Daniel Byman, September 16, 2025. <https://www.csis.org/analysis/chapter-2-will-cohesion-and-resilience>
- Resilience in the Context of National security, Spain, 2024. <https://www.dsn.gob>.

es/sites/default/files/2025-01/Resilience%20in%20the%20context%20of%20National%20Security.pdf

Gail Ridley, Resilience and National Security, University of Tasmania. DOI:10.1057/978-1-137-53675-4_5 https://www.researchgate.net/publication/318248022_Resilience_and_National_Security

Amineh Ghorbani, Saba Siddiki, Giangiacomo Bravo, Editorial: Institutional adaptation and transformation for climate resilience, 06 March 2023. <https://doi.org/10.3389/fenvs.2023.1159923> <https://www.frontiersin.org/journals/environmental-science/articles/10.3389/fenvs.2023.1159923/full>

Resilience, civil preparedness and Article 3. Updated 13 November 2024. <https://www.nato.int/en/what-we-do/deterrence-and-defence/resilience-civil-preparedness-and-article-3>

Building Europe's societal resilience, State of Union 2023. https://commission.europa.eu/strategy-and-policy/state-union/state-union-2023/building-europes-societal-resilience_en

National Resilience Strategy, January 2025. <https://bidenwhitehouse.archives.gov/wp-content/uploads/2025/01/National-Resilience-Strategy.pdf>

Building National Resilience, Cabinet Secretariat. https://www.cas.go.jp/jp/seisaku/kokudo_kyoujinka/index_en.html#:~:text=We%20are%20committed%20to%20promoting,the%20event%20of%20any%20disasters.

Building a resilient and dynamic economy. House of Representatives Standing Committee on Economics'12 February 2023. https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/About_the_House_News/Media_Releases/Building_a_resilient_and_dynamic_economy

Building the national resilience of Mongolia

Ganzorig Dovchinsuren

Doctor (Ph.D), Research Fellow, ganzorigdovchinsuren@gmail.com
The Institute for Defense Studies, Ulaanbaatar, Mongolia

Gandorj Tserendagva *

Doctor (Ph.D), Associate professor, Senior Research Fellow, gandorj@iss.gov.mn
The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Galbadrakh Togoo

Chief of Administration, togoo2@un.org
The United Nations Interim Security Force for Abyei (UNISFA)

Abstract

Core elements of the national security architecture are the National Security System and the National Resilience System. Although closely related, the two systems differ in their leadership logic and organizational design. The national security system relies on the capacities of state institutions and functions through a centralized, top-down command structure. By contrast, the National Resilience System is built on a bottom-up model that emphasizes initiative and participation from a broad range of actors, including government bodies, the private sector, civil society, and local communities.

Responding effectively to hybrid threats requires substantial financial, technical, and human resource capabilities that remain limited in many countries. Consequently, strategies to mitigate and counter hybrid threat risks must be grounded in systems thinking, broad public engagement, institutional coordination, information resilience, and innovation. In this context, the National Resilience Concept and the mechanisms for its implementation have become increasingly vital.

For Mongolia, strengthening national resilience requires formulating and implementing policies based on an integrated national data system; improving intersectoral coordination; safeguarding and advancing national values and traditions; reducing disparities among social groups; building social and economic resilience through sustained cooperation among the state, the private sector, and citizens; assessing and mitigating the impacts of global and regional instability; and aligning societal functions with disaster risk management.

Keywords: National Resilience; National Security; state; administration; institution; social; citizen; concept; policy, strategy

Received: June 15, 2026 | Accepted: June 29, 2026 | Published online: July 07, 2026



© The Author(s) 2026
<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.

* Corresponding author